



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2020 оны 6 дугаар сар



Тайланг бэлтгэсэн:

**Үндэсний аудитын газрын
Санхүүгийн аудитын газар**

Агуулга

	Товчилсон үгийн жагсаалт	1
	Нэг. Ерөнхий зүйл	2
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	3
	БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ	4
Ц.Наранчимэг	БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ	6
Аудитын менежер	2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж	6
	2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	8
Д.Энхдалай	2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл	10
	2.4 Монгол Улсын Засгийн газрын өр	10
Ахлах аудитор	БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСӨВ	13
	3.1 Улсын төсвийн орлого	13
Д.Цэрэндорж	3.2 Улсын төсвийн зарлага	16
Б.Эрдэнэзул	3.3 Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүн	17
Аудитор	3.4 Улсын төсвийн тэнцэл	18
О.Баярмаа	БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2019 ОНЫ ТӨСӨВ	19
Ч.Дашдаваа	4.1 Орон нутгийн төсвийн орлого	19
Л.Мөнхцацрал	4.2 Орон нутгийн төсвийн зарлага	20
С.Отгонхорлоо	4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл	21
Д.Цэгмиддорж	БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ	21
Ц.Энхжаргал	5.1 Нийгмийн даатгалын сангийн орлого	21
Б.Энхжин	5.2 Нийгмийн даатгалын сангийн зарлага	21
И.Эрдэнэцэцэг	5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл.	22
Ц.Цэрэннамжил	БҮЛЭГ 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ	22
Гэрээт ажилтан	6.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	22
	6.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлага	22
Ш.Ичинхорлоо	6.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл	23
Зөвлөх шинжээч	БҮЛЭГ 7. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	23
	ДҮГНЭЛТ	24
2020 оны 6 дугаар сар	ЗӨВЛӨМЖ	25
Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:	Хавсралтууд	26
www.audit.mn	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	29

**Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах зүйлийн талаар
261663 дугаарын утсаар
харилцана уу.**

ХАЯГ:

**Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр
байр, Бага тойруу-3
Улаанбаатар-15160
Монгол Улс**

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
Ам.доллар	Америк доллар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХС	Мал хамгаалах сан
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
НДС	Нийгмийн даатгалын сан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
мян.тн	мянган тонн
ОАТ	Онцгой албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОУВС	Олон улсын валютын сан
ОУБ	Олон улсын байгууллага
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨҮГ	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
тн	тонн
УИХ	Улсын Их Хурал
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМС	Эрүүл мэндийн сайд

Нэг. Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2² дахь заалтын дагуу Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7³-д заасны дагуу Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгыг дараах бүрэлдэхүүнээр тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2019 оны төсвийн гүйцэтгэл
- НДС-гийн 2019 оны төсвийн гүйцэтгэл
- ЭМДС-гийн 2019 оны төсвийн гүйцэтгэл
- Орон нутгийн 2019 оны төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын Засгийн газрын өрийн талаарх танилцуулга.

Танилцуулгын хавсралт мэдээлэлд:

- Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- Монгол Улсын 2019 оны төсвийн гүйцэтгэл
- НДС, ЭМДС, Орон нутгийн төсвийн гүйцэтгэл
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр
- Татварын зарлагын тайлан
- 2019 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
- ТЕЗ-дын 2019 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн нэгтгэлийг тус тус толилуулсан байна.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудит хийх журмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэн, Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитын тайланд орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Гүйцэтгэлийн аудитын газар аудит хийсэн тул уг тайланд оруулаагүй болно.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

¹ Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

² “төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх”

³ “нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн танилцуулгад дурдсан эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдийг Монголбанкны тайлан, Үндэсний Статистикийн хорооноос гаргасан 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээс тоймлон авч үзсэн болно.

ДНБ-ний урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт⁴ 2019 онд 5.1 хувьд хүрч, төлөвлөсөн зорилтот түвшнээс 2.9, өмнөх оноос 2.1 нэгж хувиар тус тус буурсан байна.

ДНБ-нд салбаруудын оролцоог авч үзвэл, хөдөө аж ахуй 0.5, бөөний болон жижиглэн худалдаа 0.6, үйлчилгээний бусад салбарууд 0.1 нэгж хувиар өссөн, уул уурхай 1.4, боловсруулах салбар 0.2, тээвэр, мэдээлэл, холбоо 0.3 нэгж хувиар буурсан байна.

Төлбөрийн тэнцлийн статистикаар нийт тэнцэл өмнөх онд 141.7 сая ам.долларын алдагдалтай байсан бол тайлант онд хөрөнгийн болон санхүүгийн дансны ашиг 14.1 хувиар нэмэгдэж, урсгал дансны алдагдал 17.9 хувиар буурч, нийт тэнцэл 452.8 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Гадаад худалдааны тэнцэл 1,492.3 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 31.3 хувиар өссөн, экспорт 8.7 хувь, импорт 4.3 хувиар нэмэгдсэн байна.

Инфляцийн түвшин 2019 оны жилийн эцсийн байдлаар 5.2 хувьтай гарсан нь Монголбанкны зорилтот түвшнээс 2.8 нэгж хувиар бага байна.

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголбанк 2019 онд нийт 15.2 тн үнэт металлыг худалдан авч, нөөцийг нэмэгдүүлснээр оны эцэст гадаад валютын албан нөөц 4,348.6 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 22.5 хувиар буюу 799.5 сая ам.доллараар өсчээ.

Тайлант онд Монголбанк мөнгөний бодлогын хүүг хэвээр хадгалсан байна.

⁴ Үйлдвэрлэлийн аргаарх ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр.

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1. Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд нийцүүлсэн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар зохицуулдаг.

1.2. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн бодлогод “Цахим, ил тод, үр ашигтай” байх зорилго тавин, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, ДНБ-ний 5.4 хувьд хүргэнэ;
- Татвар, гаалийн шинэчлэл болон орон нутгийн орлогын шинэчлэлийг хэрэгжүүлнэ;
- Төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, үр ашигтай хуваарилахад чиглэсэн техникийн дэвшлийг нэвтрүүлэн ил тод байдлыг сайжруулна;
- Нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулснаар эдийн засгийн өсөлтийг дэмжинэ;
- Гадаадын зээл, тусламжийг эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн үр ашигтай төсөлд зарцуулна;
- Өрийн өнөөгийн үнэ цэнэ болон ДНБ-ний харьцааг 55.3 хувь болгож, хүүгийн зардлыг бууруулна;
- Төсвийн төвлөрлийг сааруулж, орон нутгийн өмчийг эзэнд нь хариуцуулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.3. Дэвшүүлсэн зорилтоос 2 зорилт дунд хугацаанд хүлээгдэж байна.

1.4. Улсын Их Хурлаас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг анх 2018 оны 5 дугаар сарын 25-нд баталж, 2018 оны 11 дүгээр сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хүснэгт 1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Төсвийн хүрээний мэдэгдэл		Хувь	Зөрүү
		2018.05.25	2018.11.02		
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	8.0	8.0	100.0	0.0
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.0	100.0	0.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	8,888.0	9,676.5	108.9	788.5
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	25.6	27.4	107.0	1.8
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	10,993.8	11,589.8	105.4	596.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.7	32.8	103.5	1.1
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	1,342.3	1,938.2	144.4	595.9
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.9	5.5	141.0	1.6
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,105.8	- 1,913.3	90.9	192.5
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-6.1	- 5.4	88.5	0.7
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	2,890.1	3,251.8	112.5	361.7
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.3	9.2	110.8	0.9
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	19,210.2	19,551.6	101.8	341.4
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	55.3	55.3	100.0	0.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	677.9	694.5	102.4	16.6
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.0	100.0	0.0

1.5. Хүснэгтээс үзвэл, Анх баталснаас 5 сар гаруй хугацааны дараа баталсан Төсвийн хүрээний мэдэгдэлд ДНБ-ний бодит өсөлт болон хэрэглээний үнийн өсөлтийн хувь хэмжээнээс бусад үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан байна. Үүнд;

- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 788.5 тэрбум, нийт зарлагын дээд хэмжээг 596.0 тэрбум, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн хэмжээг 341.4 тэрбум, зарлагын бүтцэд

өөрчлөлт хийн хөрөнгийн зардлыг 361.7 тэрбум, нийгмийн халамжийн зардлыг 16.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг 192.5 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

1.6. Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой тооцож батлуулан төсвийн төлөвлөлтөд баримтлах талаар Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

1.7. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хоорондын орлого, зарлагын шилжүүлгийг 3,005.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,974.3⁵ тэрбум төгрөгийн гүйлгээг цэвэрлэн тайлагнажээ.

⁵ Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 368.3 тэрбум төгрөгөөр төлөвлөж, төвлөрүүлсэн; Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын болон ОНХНС-ийн шилжүүлэг, санхүүгийн дэмжлэгийг нийт 1.454.8 тэрбум төгрөгөөр төлөвлөж, 1,440.1 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн; ЭМД-ын сангаас улсын эмнэлгүүдэд олгосон татаас 253.3 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 241.8 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн, НДШ-ийн зардалд 239.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөж, 234.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл тус тус гарсан бол, Улсын төсвөөс НДС-д олгох татаасыг 689.4 тэрбум төгрөгөөр төлөвлөж, бүрэн санхүүжүүлсэн байна.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж

2.1.1 Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 12,040.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 767.8 (6.8%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 1,867.5 (18.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2018 оны гүйц	2019 оны				Өмнөх оноос	
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	10,172.8	11,272.5	12,040.3	106.8	767.8	118.4	1,867.5
Тогтворжуулалтын сан	207.0	322.0	94.6	29.4	-227.4	45.7	-112.4
Ирээдүйн өв сан	620.7	1,068.5	1,040.2	97.4	-28.3	167.6	419.5
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,345.1	9,882.0	10,905.5	110.4	1,023.5	116.7	1,560.4
Татварын орлого	8,227.8	8,694.6	9,813.2	112.9	1,118.6	119.3	1,585.4
Татварын бус орлого	1,117.3	1,187.4	1,092.3	92.0	-95.1	97.8	-25.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

/*Цэвэр дүнгээр/

2.1.2 Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 12,040.3 тэрбум, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 10,905.5 (90.6%) тэрбум, Ирээдүйн өв сангийн 1,040.2 (8.6%) тэрбум, Тогтворжуулалтын сангийн 94.6 (0.8%) тэрбум төгрөгийн орлого тус тус эзэлж байна.

2.1.3 Төсвийн тогтворжуулалтын санд 94.6 (29.4%) тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөснөөс 70.6 хувиар дутуу биелсэн нь зэсийн зах зээлийн үнэ тэнцвэржүүлсэн үнээс 267.6 ам.доллараар буурсантай холбоотой байна.

2.1.4 Төсвийн тогтворжуулалтын сангаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу төсвийн алдагдлыг санхүүжүүлэхэд 322.0 тэрбум төгрөгийг зарцуулж, 86.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.1.5 Ирээдүйн өв санд 1,040.2 (97.4%) тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөснөөс 28.3 (2.6%) тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь хувьцааны ногдол ашгийн орлогыг дутуу төвлөрүүлснээс шалтгаалжээ.

2.1.6 Ирээдүйн өв сангаас улсын төсөвт 50.0 тэрбум төгрөг шилжүүлж, улсын төсөвт төлөх 466.3 тэрбум төгрөгийн өглөг барагдуулснаар 538.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.1.7 Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнгийн 56.0 хувийг улсын, 21.4 хувийг орон нутгийн, 19.0 хувийг НДС-гийн, 3.6 хувийг ЭМДС-гийн орлого тус тус бүрдүүлж байна.

2.1.8 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 10,905.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 1,023.5 (10.4%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 1,560.4 (16.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	2018 оны гүйц	2019 оны			
			Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн*	10,172.8	11,272.5	12,040.3	106.8	767.8
2	Улсын төсвийн орлого	7,656.1	8,744.2	9,112.4	104.2	368.2
3	Орон нутгийн төсвийн орлого	2,769.3	2,917.2	2,947.6	101.0	30.4
4	НДС-гийн төсвийн орлого	2,090.1	2,208.8	2,485.0	112.5	276.2
5	ЭМДС-гийн орлого	411.1	407.7	469.6	115.2	61.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл


/*Цэвэр дүнгээр/

2.1.9 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн өсөлтөд татварын орлого давж биелсэн нь нөлөөлсөн бөгөөд орлогын 90.0 хувийг татварын, 10.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

2.1.10 Татварын орлого 9,813.2 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 1,118.6 (12.9%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 1,585.4 (19.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

2.1.11 Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлд орлогын албан татвар 441.6 тэрбум, НДШ 343.0 тэрбум, НӨАТ 165.2 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Дүрслэл 1. Татварын ачаалал сүүлийн 5 жилийн байдлаар /тэрбум төгрөг/



2.1.12 Татварын орлогын ДНБ-д эзлэх эдийн засаг дахь татварын ачаалал 26.6 хувьд хүрч өмнөх оноос 1.0 хувиар өссөн байна.

2.1.13 Дээрх үзүүлэлт нь ДНБ-ний өсөлт харьцангуй тогтвортой байгаа болон уул уурхайн салбарын орлого өссөнтэй холбоотой байна.

2.1.14 Уул уурхайн салбарын орлого 3,138.5 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 138.4 (4.6%) тэрбум, өмнөх оноос 744.9 (31.1%) тэрбум төгрөгөөр давж биелсэн нь алт, төмрийн хүдрийн зах зээлийн үнэ өссөн, жоншны биет хэмжээ 2 дахин, бусад орлого 96.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн зэргээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 4. Уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ, тэнцвэржүүлсэн үнэ, нийт орлого

№	Бүтээгдэхүүн нэр төрөл	Биет хэмжээ			Үнэ, ам.доллар/нэгж			Нийт орлого /тэрбум төгрөг/		
		2018 гүйц	2019 он		2018 гүйц	2019 он		2018 гүйц	2019 он	
			Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц
1	Зэсийн баяжмал /мян.тн/	1,436.7	1,400.0	1,403.6	6,524.8	6,272.2	6,004.6	999.0	1,304.4	1,333.3
2	Нүүрс /мян.тн/	36,265.1	42,000.0	36,748.8	77.3	75-100	84.5	998.0	1,310.8	1,282.2
3	Алт /тн/	18.1	21.0	13.2	1,266.5	1,262.1	1,389.6	80.0	82.5	116.8
4	Цайр /мян.тн/	123.9	78.2	134.8	1,596.3	2,899.2	2,548.6	78.0	56.2	67.6
5	Төмрийн хүдэр /мян.тн/	7,449.0	7,550.0	8,448.8	45.9	40.0	68.3	31.5	67.2	47.5
6	Жонш /мян.тн/	555.2	360.0	699.4	341.9	355.0	293.5	18.2	23.1	39.3
7	Бусад	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	188.9	155.9	251.8
Нийт дүн								2,393.6	3,000.1	3,138.5

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.1.15 Уул уурхайн гол нэрийн зарим эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээг өөдрөг төлөвлөснөөс үүссэн орлогын зөрүүг үнийн өсөлттэй бүтээгдэхүүний орлогоор нөхсөн байна.

2.1.16 Нэгдсэн төсвийн нийт орлогын 26.1 хувийг уул уурхайн салбарын орлого эзэлж байгаа нь өмнөх оноос 2.6 нэгж хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Уул уурхайн салбарын татварын орлогын гүйцэтгэл сүүлийн 4 жилийн байдлаар /тэрбум төгрөг/

Орлогын албан татвар	Он				
	2016	2017	2018	2019	2019/2018
АМНАТ	288.7	847.8	1,047.0	1,425.7	136.2
ААНОАТ	225.8	443.7	653.1	869.2	133.1
НӨАТ	22.1	30.8	31.3	43.1	137.7
Бусад	231.0	300.8	662.2	800.5	120.9
Дүн	767.6	1,623.1	2,393.6	3,138.5	131.1

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.1.17 Уул уурхайн салбарын 2019 оны нийт орлогын 45.4 хувийг АМНАТ, 27.7 хувийг ААНОАТ, 1.4 хувийг НӨАТ, 25.5 хувийг бусад татварын болон татварын бус орлого тус тус бүрдүүлсэн байна.

2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

2.2.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019 оны Төсвийн хүрээний мэдэгдлээр нийт зарлагын дээд хэмжээг 11,589.8 тэрбум төгрөгөөр баталсан байна.

2.2.2 Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө Төсвийн хүрээний мэдэгдлээр баталснаас 516.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн ИТХ-аас эцэслэн баталсан төсвөөр Сангийн яамны хянасан суурь зарлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 6. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөлт */тэрбум төгрөг/*

Үзүүлэлт	Жилийн хязгаар	2019 оны			
		УИХ-д өргөн барьсан	УИХ-аар батлагдсан	Зөрүү	Хувь
1	2	3	4	5=3-2	6=3/2
НЭГДСЭН ТӨСӨВ*		11,589.8	11,589.1		
Улсын төсөв	8,883.2	9,357.2	9,406.6	474.0	105.3
Орон нутгийн төсөв ⁶	2,701.9	2,849.6	2,701.9	147.7	105.5
Нийгмийн даатгалын сангийн төсөв	2,053.6	2,068.5	2,068.5	14.9	100.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	361.8	407.7	407.7	45.9	112.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

*/*Цэвэр дүнгээр/*

2.2.3 Хүснэгтээс үзвэл, Сангийн яам улсын төсвийг батлагдсан хязгаараас 474.0 (5.3%) тэрбум, ЭМДС-гийн төсвийг 45.9 (12.7%) тэрбум, НДС-гийн төсвийг 14.9 (0.7%) тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн өргөн барьсан байна.

2.2.4 Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 11,661.7 тэрбум төгрөгт хүрч, 96.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 7. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн зарлагын бүтэц */тэрбум төгрөг/*

Үзүүлэлт	2018 оны гүйцэт	2019 оны				Өмнөх оны зөрүү
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	
1	2	3	4	5=4/3	6=4-3	7=4-2
Нэгдсэн төсөв*	9,317.2	12,106.5	11,661.7	96.3	-444.8	2,344.5
Улсын төсөв	7,181.9	9,406.6	9,295.1	98.8	-111.5	2,113.2
Орон нутгийн төсөв	2,762.7	3,229.1	2,927.7	90.7	-301.4	165.0
Нийгмийн даатгалын сангийн төсөв	1,814.6	2,068.5	2,062.3	99.7	-6.3	247.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв	311.7	407.7	351.0	86.1	-56.7	39.3

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

*/*Цэвэр дүнгээр/*

2.2.5 Хүснэгтээс үзвэл, Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өмнөх оноос 39.3-2,113.2 тэрбум төгрөгөөр өссөн нь улсын болон бусад төсвийн урсгал зарлага өмнөх оноос 6.0-29.4 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2.6 Төлөвлөснөөс орон нутгийн төсвийн зардлыг 301.4 тэрбум, улсын төсвийн зардлыг 111.5 тэрбум, ЭМДС-гийн төсвийн зардлыг 56.7 тэрбум, НДС-гийн төсвийн зардлыг 6.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

2.2.7 Сүүлийн 3 жилийн байдлаар орлогын өсөлтийн хурд саарсан, зарлагын өсөлтийн хурд идэвхжих хандлагатай байна.

Хүснэгт 8. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж, зарлага ба цэвэр зээлийн судалгаа

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Он				Өсөлтийн хурд		
	2016	2017	2018	2019	2016 /2017	2017 /2018	2018 /2019
Нийт орлого ба тусламжийн дүн	5,835.0	7,958.3	10,172.8	12,040.3	1.36	1.28	1.18
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9,495.3	9,017.3	9,317.2	11,661.7	0.95	1.03	1.25

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

⁶ Сангийн яамны хянасан дүн

2.2.8 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл төлөвлөснөөс 444.8 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь урсгал зарлагыг 303.6 тэрбум, хөрөнгийн зардлыг 388.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 247.7 тэрбум төгрөгөөр илүү зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 9. Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн эдийн засгийн ангилал

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2018 оны гүйц	2019 оны				Өмнөх оны зөрүү
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	
1	2	3	4	5=4/3	6=4-3	7=4-2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9,317.2	12,106.5	11,661.7	96.3	-444.8	2,344.5
A Урсгал зарлага	7,350.3	8,532.2	8,228.6	96.4	-303.6	878.3
1 Бараа, үйлчилгээний зардал	3,327.5	4,170.2	4,000.5	95.9	-169.7	673.0
2 Хүү	1,046.4	865.6	861.0	99.5	-4.6	-185.4
3 Татаас ба урсгал шилжүүлэг	2,976.4	3,496.4	3,367.1	96.3	-129.3	390.7
Б Хөрөнгийн зардал	1,680.4	3,405.6	3,016.7	88.6	-388.9	1,336.3
В Эргэж төлөгдөх цэвэр зээл	286.5	168.7	416.4	246.8	247.7	129.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.2.9 Зарцуулагдаагүй нийт зарлага ба цэвэр зээлийн 21.1 хувийг улсын төсөв, 67.3 хувийг орон нутгийн төсөв, 10.2 хувийг ЭМДС-гийн төсөв, 1.4 хувийг НДС-гийн төсөв тус тус эзэлж байна.

2.2.10 ТЕЗ-д хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй 304 төсөл, арга хэмжээний 159.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, хөрөнгийн зардлын гүйцэтгэлийг⁷ 4.6 хувиар өсгөж тайлагнасан байна.

2.2.11 Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх" тухай Сангийн сайдын 2013 оны 73, 2019 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус баримтлан тайлант онд Сангийн сайдын 12 тушаалаар хуваарьт өөрчлөлт оруулж, төсвийн зардлын бүлэг хооронд 8.9 тэрбум төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

2.2.12 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 168.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 369.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд 6 ТЕЗ-д нийт 491.4 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээлийг олгож, өмнөх онуудад олгосон зээлээс 122.3 тэрбум төгрөг төвлөрүүлжээ.

Хүснэгт 10. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл

/тэрбум төгрөг/

ТЕЗ	Төсөл хөтөлбөрийн нэр	2019 оны		Зөрүү
		Төлөв	Гүйц	
Олгосон зээл, үүнээс		460.3	491.4	31.1
БСШУСС	Боловсролын зээлийн сан	54.8	47.0	-7.8
Сангийн сайд	Олгох зээл /13 төсөл, арга хэмжээ/	240.4	355.4	115.0
ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	47.0	47.4	0.4
	ТЭДС	22.0	13.6	-8.4
	Мал хамгаалах сан	1.5	0.0	-1.5
БХБС	"Түрээсийн орон сууц" хөтөлбөр	5.0	5.0	0.0
БОАЖС	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	49.0	0.0	-49.0
Орон нутаг	18 аймгийн ТЕЗ-д	40.6	23.0	-17.6
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс		-291.6	-122.3	-169.3
ХХААХҮС	ЖДҮХС,ТЭДС, МХС	-142.3	-55.7	-86.6
Сангийн сайд	ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төсөл	-123.7	-63.1	-60.6
ХЗДХС	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	-20.6	0.0	-20.6
БСШУСС	Боловсролын зээлийн сан	-5.0	-3.5	-1.5
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		168.7	369.1	200.4

Эх сурвалж: Сангийн яам

⁷ Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 1.1-д "... төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах"



2.2.13 Тайлант онд Сангийн сайд, БСШУСС, ХХААХҮС, БХБС болон орон нутгийн ТЕЗ-д нийт 314.6 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөснөөс 41.0 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь 21 аймгийн ТЕЗ-д 17.6 тэрбум, ТЭДС 8.4 тэрбум, сургалтын зээл 7.8 тэрбум, Моргейжийн хөтөлбөр 3.9 тэрбум, бусад төсөл, сангаас 3.3 тэрбум төгрөгийн зээл олгоогүйтэй холбоотой байна.

2.2.14 Төслүүдэд 76.6 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 95.7 тэрбум төгрөгийг олгож, 19.1 тэрбум төгрөгөөр хэтэрчээ.

2.2.15 Гадаад эх үүсвэрээс санхүүжих 4 төсөлд нийт 102.1 тэрбум төгрөгийн төлөвлөгдөөгүй зээл олгосон байна.

2.2.16 Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээл төлөвлөснөөс 169.3 тэрбум төгрөгөөр буюу 58.1 хувиар дутуу байна. Үүнд: ХХААХҮС 86.6 тэрбум, Сангийн сайд 60.6 тэрбум, БСШУСС 1.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлээгүй, ХЗДХС 20.6 тэрбум төгрөгийн авлага хуульд орсон өөрчлөлтийн улмаас эргэн төлөгдөх нь эрсдэлтэй байна.

2.2.17 БОАЖС дотоод эх үүсвэрээс 49.0 тэрбум төгрөгийн зээл олгохоор батлагдсан боловч 43.8 тэрбум төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлж, зориулалт бусаар зарцуулж, тайлагнасан байна. Тухайлбал,

- Сайжруулсан шахмал түлш үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх;
- Сургууль, цэцэрлэгийн нам даралтын зуухыг хийн зуухаар солих;
- Цахилгаан бага зарцуулдаг бойлуур, усан халаалтын бага, дунд оврын зуухны утааны хийн шүүлтүүр, угаарын хий мэдрэгч бэлтгэх;
- Гэр хорооллын айл өрхийн цахилгааны шөнийн тарифын хөнгөлөлтөд зарцуулжээ.

2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл

2.3.1 Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,224.5 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс 1,468.3 тэрбум төгрөгөөр буурч, 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байгаа нь ДНБ-ний 2.0 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 11. Нэгдсэн төсвийн тэнцэл /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2018 оны гүйц	2019 оны		
		Төлөв	Гүйц	Зөрүү
Нэгдсэн төсөв	27.9	-2,224.5	-756.2	1,468.3
Улсын төсөв	-353.5	-2,052.9	-1,317.5	735.4
Орон нутгийн төсөв	6.6	-311.9	19.9	331.8
НДС-гийн төсөв	275.5	140.3	422.7	282.4
ЭМДС-гийн төсөв	99.3	0.0	118.7	118.7

2.3.2 Тайлант онд төлөвлөснөөс улсын төсвийн алдагдал 735.4 тэрбум төгрөгөөр буурч, НДС 422.7 тэрбум, ЭМДС 118.7 тэрбум, орон нутгийн төсөв 19.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.3.3 Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 1,623.6 тэрбум төгрөгийн гадаад зээл авч Ирээдүйн өв сангаас 50.0 тэрбум, Тогтворжуулалтын сангаас 322.0 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт шилжүүлж, Ирээдүйн өв сангийн 466.3 тэрбум төгрөгийн авлага барагдуулж, өмч хувьчлалын орлогоос 1.0 тэрбум, нийт 2,462.9 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

2.3.4 Дээрх эх үүсвэрүүдээс Засгийн газрын дотоод үнэт цаасны эргэн төлөлтөд 165.1 тэрбум, гадаад зээлийн үндсэн төлбөрт 438.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, 756.2 тэрбум төгрөгөөр төсвийн алдагдлыг санхүүжүүлж, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 1,103.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.4 Монгол Улсын Засгийн газрын өр

2.4.1 Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр 2019 оны жилийн эцэст 20,525.6 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ний 55.6 хувьтай тэнцүү байна.

Хүснэгт 12. Монгол Улсын Засгийн газрын өрийн үлдэгдэл сүүлийн 4 жилийн байдлаар

/тэрбум төгрөг/

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл	2016.12.31	2017.12.31	2018.12.31	2019.12.31	Өөрчлөлт 2018-2019	Дүнд эзлэх хувь
I. Засгийн газрын дотоод өр	5,796.0	3,461.9	1,564.7	1,399.6	-165.1	5.8
1.1 Үнэт цаас	5,488.8	3,461.9	1,564.7	1,399.6	-165.1	5.8
1.2 Өрийн бичиг	307.2	0.0	0.0	0.0	0.0	0.0
II. Засгийн газрын гадаад өр	12,363.8	16,857.8	18,865.6	20,728.1	1,862.5	85.7
2.1 Үнэт цаас	5,380.5	7,701.6	7,664.5	7,927.2	262.7	32.8
2.2 Зээл	6,983.3	9,156.2	11,201.1	12,800.9	1,599.8	52.9
III Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,663.7	1,130.7	1,076.3	-54.4	4.4
IV Барих-шилжүүлэх төрлийн концесс	668.9	768.2	806.0	995.7	189.7	4.1
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)	22,280.1	22,751.6	22,367.0	24,199.7	1,832.7	100.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (өнөөгийн үнэ цэнэ)	18,861.0	20,212.1	18,955.9	20,525.6	1,569.7	
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	88.0	85.0	80.0	75.0	5.0	
Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь	78.8	72.5	58.9	55.6	3.3	
Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь	93.1	81.6	69.5	65.6	3.9	
ДНБ	23,942.9	27,895.5	32,166.0	36,897.6	4,731.6	

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.2 Хүснэгтээс үзвэл, Засгийн газрын 2019 оны нийт өрийн үлдэгдлийн 85.7 хувийг гадаад өр, 5.8 хувийг дотоод өр, 4.4 хувийг өрийн баталгаа, 4.1 хувийг “барих-шилжүүлэх” төрлийн концесс тус тус эзэлж байна.

2.4.3 Өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ний 55.6 хувьтай тэнцэж байгаа нь тайлант оны зорилтот түшингээс 0.3 хувиар хэтэрсэн боловч, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр тооцсон үлдэгдэл 2019 онд ДНБ-ний 75.0 хувиас хэтрэхгүй байхаар заасныг хангасан байна.

2.4.4 Засгийн газрын нийт өр 1,832.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Засгийн газрын 2019 оны төсвийн жилд нэмэгдүүлэх өр болон өрийн баталгааны дээд хэмжээг 2,169.1 тэрбум төгрөгөөр баталсугай” гэж заасантай нийцэж байна.

2.4.5 Тайлант онд стратегийн баримт бичгийн хүрээнд Засгийн газрын өрийн баталгаа, “барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ зэрэг болзошгүй өр төлбөр үүсгэх өрийн хэрэгслийн гэрээг шинээр байгуулахгүй байх зэрэг бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 13. Засгийн газрын 2019 оны өрийн бүтэц

/тэрбум төгрөг/

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн зөрүү	Хүүгийн төлбөр	Эцсийн үлдэгдэл
I. Засгийн газрын дотоод өр	1,564.7	0.0	165.1	0.0	185.7	1,399.6
1.1 Үнэт цаас	1,564.7	0.0	165.1	0.0	185.7	1,399.6
II. Засгийн газрын гадаад өр	18,865.6	1,638.6	438.3	662.2	675.2	20,728.1
2.1 Үнэт цаас	7,664.5	0.0	0.0	262.7	167.5	7,927.2
2.2 Зээл	11,201.1	1,638.6	438.3	399.5	507.7	12,800.9
III Засгийн газрын өрийн баталгаа	1,130.7	3.9	102.6	44.3	0.0	1,076.3
IV Барих-шилжүүлэх төрлийн концесс	806.0	189.7	0.0	0.0	0.0	995.7
Нийт	22,367.0	1,832.2	706.0	706.5	860.9	24,199.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.6 Засгийн газрын гадаад өрийн 2019 оны үлдэгдэл валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан 706.5 тэрбум төгрөгөөр өссөн байна. /Монголбанкны хаалтын ханш 1 ам.доллар 2,733.52 төгрөг/

2.4.7 Засгийн газрын дотоод үнэт цаас: Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 1,564.7 тэрбум төгрөг байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар 1,399.6 тэрбум төгрөг болж, 165.1 тэрбум төгрөгөөр буурсан ба шинээр дотоод үнэт цаас гаргаагүй байна.

2.4.8 Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 947.6 тэрбум төгрөг буюу 67.7 хувийг төсвийн алдагдлыг, 374.0 тэрбум төгрөг буюу 26.7 хувийг Сайн хувьцаа хөтөлбөрийг, 78.0 тэрбум төгрөг буюу 5.6 хувийг Хүний хөгжил сангийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас тус тус эзэлж байна.

2.4.9 Засгийн газрын гадаад үнэт цаас: Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 2018 онд 7,664.5 тэрбум төгрөг байсан бол 2019 оны жилийн эцсийн байдлаар гадаад валютын ханшийн өөрчлөлтөөр 262.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 7,927.2 тэрбум төгрөг болсон байна.

Хүснэгт 14. Гадаад үнэт цаас

/тэрбум төгрөг/

Гадаад үнэт цаас	Гаргасан огноо	Хүүгийн хувь	Эхний үлдэгдэл		Ханшийн өөрчлөлт /тэрбум төгрөг/	2019 оны эцсийн үлдэгдэл		Эргэн төлөх огноо
			сая ам.доллар	тэрбум төгрөг		сая ам.доллар	тэрбум төгрөг	
ЧИНГИС-12-1.0	12/05/2012	5.125	1,000.0	2,642.9	90.6	1,000.0	2,733.5	2022 он
ГЭРЭГЭ	1/11/2017	5.625	800.0	2,114.3	72.4	800.0	2,186.7	2023 он
ХУРАЛДАЙ	3/09/2017	8.750	600.0	1,585.8	54.4	600.0	1,640.2	2024 он
МАЗААЛАЙ	4/06/2017	10.875	500.0	1,321.5	45.3	500.0	1,366.8	2021 он
НИЙТ ДҮН			2,900.0	7,664.5	262.7	2,900.0	7,927.2	

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.10 Засгийн газраас шинээр гадаад үнэт цаас гаргаагүй бөгөөд тайлант онд 203.1 сая ам.доллар буюу 507.7 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлсөн байна.

2.4.11 Засгийн газрын гадаад зээл: Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 4,682.9 сая ам.доллар буюу 12,800.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 1,599.8 тэрбум төгрөгөөр өссөн ба Засгийн газрын нэрлэсэн үнээр илэрхийлсэн нийт өрийн 58.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 15. Засгийн газрын гадаадаас авсан хөнгөлөлттэй

нөхцөлтэй зээл

/тэрбум төгрөг/

Салбарын ангилал	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн		Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
		Ашиглалт	Ханшийн зөр	Үндсэн төлбөр	
Төслийн зээл	8,515.7	1,230.5	302.8	279.0	9,770.0
Хөтөлбөрийн зээл	2,114.5	408.1	81.8	0.0	2,604.4
Арилжааны зээл	570.9	0.0	14.9	159.3	426.5
НИЙТ ДҮН	11,201.1	1,638.6	399.5	438.3	12,800.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.12 Засгийн газар 2019 онд ОУБ, хөгжлийн түнш орнуудаас төслийн зээл 1,230.5 тэрбум, ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” -ийн хүрээнд 408.1 тэрбум, нийт 1,638.6 тэрбум төгрөгийн буюу 608.3 сая ам.долларын гадаад зээл авсан байна.

2.4.13 Тайлант онд ОУВС-гийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд 578.6 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл авахаар төлөвлөснөөс, 408.1 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалт гарч, 170.5 тэрбум төгрөгийн зээлийг ашиглаагүй нь ОУВС-гийн 6 дахь шатны чанарын үнэлгээний дүн эцэслэн гараагүйгээс шалтгаалжээ.

2.4.14 Засгийн газрын гадаад зээлийн үндсэн төлбөрт 851.8 тэрбум төгрөг төлөвлөснөөс 438.3 тэрбум төгрөгийн төлбөрийг гүйцэтгэж, 413.5 тэрбум төгрөгийн зээлийн төлөлт хийгдээгүй нь төлөвлөсөн арилжааны нөхцөлтэй зээлийг хугацаанаас нь өмнө төлөх эх үүсвэр хүрэлцээгүйгээс шалтгаалсан байна.

2.4.15 “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдаагүй зарим төсөл, хөтөлбөрт 34.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна.

2.4.16 Засгийн газрын өрийн баталгаа: Тайлант онд 3.9 тэрбум төгрөгийн ашиглалт гарч, эргэн төлөлтөд 102.5 тэрбум төгрөг төлж, ханшийн өөрчлөлтөөр 44.2 тэрбум төгрөг нэмэгдэж нийт 1,076.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 16. Засгийн газрын өрийн баталгаа

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
Хөгжлийн банк	1,003.6	0.0	71.6	40.6	972.6	90.4
“МИАТ” ХК	107.4	0.0	30.8	2.8	79.4	7.4
“Эрдэнэс Монгол” ХХК	19.7	3.9	0.1	0.8	24.3	2.2
Өрийн баталгааны дүн	1,130.7	3.9	102.5	44.2	1,076.3	100.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.17 Барих-шилжүүлэх төрлийн концесс: Эргэн төлөх концессын өрийн ашиглалт тайлант онд 189.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 995.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс Улсын төсвөөс эргэн төлөгдөх нийт 16 гэрээний үлдэгдэл 993.5 тэрбум төгрөг, орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нийт 7 гэрээний үлдэгдэл 2.2 тэрбум төгрөг байна.

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2019 ОНЫ ТӨСӨВ

3.1 Улсын төсвийн орлого

3.1.1 Монгол Улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2019 онд 9,112.4 тэрбум, нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж нь 7,977.6 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт орлогын 87.5 хувийг эзэлж байна.

3.1.2 Тайлант онд Улсын төсвийн нийт орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 1,456.3 (19.0%), төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 1,149.2 (16.8%) тэрбум, Ирээдүйн өв сангийн хуримтлал 419.5 тэрбум төгрөгөөр өссөн, Тогтворжуулалтын сангийн хуримтлал 112.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.1.3 Монгол Улсын 2019 оны төсвийн нийт орлого ба тусламжийн 71.3 хувийг татварын орлого, 16.3 хувийг татварын бус орлого, 11.4 хувийг Ирээдүйн өв сангийн орлого, 1.0 хувийг Тогтворжуулалтын сангийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 17. Улсын төсвийн нийт орлого ба тусламжийн гүйцэтгэл сүүлийн 4 жилийн байдлаар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	он	2016	2017	2018	2019
Нийт орлого ба тусламжийн дүн		3,894.4	5,857.1	7,656.1	9,112.4
Тогтворжуулалтын сан		0.0	325.7	207.0	94.6
Ирээдүйн өв сан		0.0	357.7	620.7	1,040.2
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламж		3,894.4	5,173.7	6,828.4	7,977.6
Үүнээс	Татварын орлого	2,854.1	3,987.2	5,430.6	6,493.5
	Татварын бус орлого	1,040.4	1,186.5	1,397.7	1,484.1

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.1.4 Улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнгийн 81.4 хувийг татварын орлого, 18.6 хувийг татварын бус орлого тус тус бүрдүүлсэн байна.

3.1.5 Татварын нийт орлого тайлант онд 6,493.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1,062.9 (19.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.1.6 Татварын орлогын 38.3 хувийг НӨАТ, 13.3 хувийг ОАТ, 25.6 хувийг орлогын албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 12.2 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 10.4 хувийг бусад татвар (төлбөр хураамж) тус тус бүрдүүлсэн байна.

3.1.7 Татварын орлогын төлөвлөгөө давж биелэхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- ДНБ 5.1 хувиар өссөн;
- Гадаад худалдааны эргэлт өмнөх оноос 860.0 (6.7%) тэрбум, үүнээс, экспорт 608.8 (8.7%) тэрбум, импорт 252.6 (4.3%) тэрбум төгрөгөөр;
- Уул уурхайн голлох нэр төрлийн зарим эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээ, үнэ өмнөх оноос өссөнөөс салбарын орлого 744.9 (31.1%) тэрбум төгрөгөөр;
- НӨАТ-ын урамшууллын системийн цахим төлбөрийн баримтын тоо 309.6 саяд хүрч, өмнөх оноос 7.1 хувиар, ногдолтой тайлангийн тоо 2922-оор тус тус өссөн.

3.1.8 ААНОАТ-ын орлого 1,660.5 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 420.5 (33.9%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 383.6 (30.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. ААНОАТ-ын гүйцэтгэлд эдийн засгийн өсөлт, гадаад худалдааны эргэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

3.1.9 НӨАТ-ын орлого 2,486.3 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 165.2 (7.1%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 290.4 (13.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.1.10 ОАТ-ын орлого 863.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 25.6 (3.0%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 109.0 (14.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Орлого гүйцэтгэлд автобензин, дизель түлшний төлөвлөгөө 23.7 хувиар буюу 50.0 тэрбум, импортын архи, тамхи 19.8 хувиар буюу 20.6 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.

3.1.11 Тусгай зориулалтын орлого 16.4 тэрбум төгрөгт хүрч төлөвлөснөөс 4.2 (34.4%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 3.3 (25.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.1.12 Гадаад үйл ажиллагааны орлого тайлант онд 790.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 47.2 (6.3%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 108.0 (15.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд гадаад худалдааны нийт бараа эргэлт өмнөх оноос 6.7 хувиар, үүнд импорт 12.1 хувиар, экспорт 8.7 хувиар, татвартай импорт 15.8 хувиар өсч, төгрөгийн ам.доллартой харьцах харьцаа дунджаар 7.9 хувиар суларсан нь нөлөөлжээ.

3.1.13 Бусад татвар (төлбөр хураамж)-ийн орлого тайлант онд 676.7 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 76.1 (12.6%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 168.6 (33.2%) тэрбум төгрөгөөр өсжээ.

3.1.14 **Татварын бус орлого** тайлант онд 1,484.1 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 114.9 (7.2%) тэрбум төгрөгөөр дутуу биелсэн бол өмнөх оноос 86.4 (6.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтэд нийтлэг бус татварын орлого төлөвлөснөөс 46.3 (5.5%) тэрбум, тусламжийн орлого 68.5 (9.0%) тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн нь нөлөөлжээ.

3.1.15 Хувьцааны ногдол ашгийн орлогоос 2019 онд Ирээдүйн өв санд 300.9 тэрбум, улсын төсөвт 9.9 тэрбум, нийт 310.8 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцжээ.

3.1.16 Тайлант онд хувьцааны ногдол ашиг 179.9 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 130.9 (42.1%) тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар баталсан ногдол ашгийн орлогыг ТӨБЗГ 162.7 (52.3%) тэрбум төгрөгөөр тооцон дутуу ногдуулалт хийсэнтэй холбоотой байна.

3.1.17 Хувьцааны ногдол ашгийг дутуу ногдуулснаар Ирээдүйн өв санд 148.1 тэрбум төгрөгийн хуримтлал бий болох боломжийг алдсан байна.

3.1.18 Хувьцааны ногдол ашгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ дутуу биелэхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- ТӨБЗГ 2018 онд ашигтай ажилласан “Эрдэнэс таван толгой” ХХК-ийн 121.1 тэрбум, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2.7 тэрбум, “Үндэсний давхар даатгал” ТӨХК-ийн 0.6 тэрбум, “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн 0.1 тэрбум, нийт 124.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тооцож ногдуулаагүй;
- Тайлант оны дундуур Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоол зэрэг шийдвэрээр ногдол ашгаас төвлөрүүлэх орлогыг бууруулсан;

- ТБОНӨҮГ, ХК-ийн тухайн тайлант оны ашгаас хувьцааны ногдол ашиг тооцох хувь, хэмжээ болон чөлөөлөлт, хөнгөлөлт эдлүүлэх талаар баримтлах бодлого, журам, заавар тодорхой бус;
- Тайлант онд зарим ТӨҮГ-ууд ногдол ашгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн. Тухайлбал, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв 59.6 тэрбум, МИАТ ХК 7.3 тэрбум, Налайхын дулааны станц 0.1 тэрбум төгрөг.

3.1.19 Газрын тосны орлого 231.7 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 103.9 (30.9%) тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь экспортын хэмжээ төлөвлөснөөс 1.6 сая баррелиар бага байгаагаас шалтгаалжээ.

3.1.20 Навигацын орлогоор тайлант онд 156.0 тэрбум төгрөгийг бүрдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн ч өмнөх оноос 11.7 (7.0%) тэрбум төгрөгөөр буурсан нь ИНЕГ-ын үйл ажиллагаанд навигацын орлогоос зарцуулах хэмжээг өндөр дүнгээр баталснаас шалтгаалсан байна.

3.1.21 Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого Тайлант онд 267.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй буюу төлөвлөснөөс 27.4 (11.4%) тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 22.9 (7.9%) тэрбум төгрөгөөр буурчээ.

3.1.22 Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого нийт дүнгээр давж биелсэн боловч ХНХС 22.4 тэрбум, ХХААХҮС 10.7 тэрбум, БСШУСС 3.8 тэрбум, БХС 1.9 тэрбум, УУХҮС 0.3 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелүүлсэн байна.

3.1.23 Тусламжийн орлогын эх үүсвэрээр тайлант онд нийт 42 төсөл, арга хэмжээнд 146.0 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 36 нь хэрэгжиж, 85.2 (58.3%) тэрбум төгрөгийн тусламжийн ашиглалт гарч, өмнөх оноос 0.1 (0.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.1.24 Тусламжийн орлогын ашиглалт дутуу гарсан нь дараах шалтгаантай байна.
Тухайлбал,

- Шинээр хэрэгжүүлж эхлэх 6 төсөл, арга хэмжээ нь хөгжлийн түнш улс, ОУБ болон дотоодын төсөл хэрэгжүүлэгч байгууллагаас шалтгаалан гэрээний шатандаа байгаагаас 8.7 тэрбум, хэрэгжилт цуцлагдсан 1 төсөл, арга хэмжээний 2.6 тэрбум, нийт 11.3 тэрбум;
- Хэрэгжиж эхэлсэн 9 төсөл, арга хэмжээ 30.0 хувийн гүйцэтгэлтэйгээс 11.4 тэрбум;
- Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 10 төсөл, арга хэмжээ 76.9 хувийн гүйцэтгэлтэйгээс 22.5 тэрбум;
- Хэрэгжиж дуусах 9 төсөл, арга хэмжээнд 11.7 тэрбум төгрөгийн тусламжийн орлогыг төлөвлөснөөс зарим эх үүсвэрийг өмнөх оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдлээс санхүүжүүлснээр 15.5 тэрбум, нийт 60.7 тэрбум төгрөг.

Татварын зарлага:

3.1.25 Тайлант онд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 522.3 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн нийт татварын орлогын 5.3 хувьтай тэнцэж байгаа нь өмнөх оны түвшнээс 0.6 хувиар буурсан байна.

3.1.26 Тайлант онд 15 хууль эрх зүйн актын хүрээнд 1079 иргэн, хуулийн этгээдэд хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдлүүлсэн байна.

Хүснэгт 18. Татварын зарлагын гүйцэтгэл /тэрбум төгрөг/

Байгууллага	2018 он	2019 он	Зөрүү	Бүтэц хувиар
Татварын орлого	8,227.8	9,813.2	1,585.4	19.2
Нийт татварын зарлага	487.0	522.3	35.3	100.0
Татварын орлогод эзлэх татварын зарлагын хувь	5.9	5.3	-0.6	0.0
Татварын байгууллага	298.6	307.5	8.9	58.9
ААНОАТ	42.4	53.8	11.4	10.3
Хувь хүний орлогын албан татвар	142.9	178.6	35.7	34.2
НӨАТ	113.3	75.1	-38.2	14.4
Гаалийн байгууллага	188.4	214.8	26.4	41.1
Гаалийн албан татвар	24.0	27.5	3.5	5.3
ОАТ	104.7	125.1	20.4	24.0
НӨАТ	59.7	62.2	2.5	11.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.1.27 Тайлант оны нийт татварын зарлагын 58.9 хувийг татварын, 41.1 хувийг гаалийн байгууллагын хөнгөлөлт, чөлөөлөлт тус тус эзэлж байна.

3.1.28 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт 26.9 хувиар, хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт 25.0 хувиар тус тус нэмэгдэж, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн чөлөөлөлт 20.6 хувиар буурсан байна.

3.2 Улсын төсвийн зарлага

3.2.1 Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар нийт зарлага ба цэвэр зээлийг 9,406.6 тэрбум төгрөгөөр баталж, өмнөх оны гүйцэтгэлээс 2,224.7 тэрбум төгрөг буюу 31.0 хувиар нэмэгдүүлсэн байна.

3.2.2 Зарим ТЕЗ-д төсвийн саналаа төсвийн хязгаараас 5,041.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн, хөтөлбөр, арга хэмжээний тооцоолол, үндэслэл, тайлбар хангалтгүй байгаа зэрэг нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 31 дүгээр зүйлийн 31.2⁸ дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

3.2.3 Тайлант онд нийгмийн халамжийн хөтөлбөрт 333.2 тэрбум, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд 117.5 тэрбум, эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэхэд 111.7 тэрбум, агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд 58.9 тэрбум төгрөгийг тус тус нэмэгдүүлэн төлөвлөжээ.

3.2.4 Тайлант онд улсын төсвийн зарлага 9,295.1 тэрбум төгрөг буюу 98.8 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 111.5 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

Хүснэгт 19. Монгол Улсын 2019 оны төсвийн зарлагын эдийн засгийн ангилал /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2018 оны гүйц	2019 оны				Дүнд эзлэх хувь
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	
А	1	3	4	5=4/3	6=4-3	7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,181.9	9,406.6	9,295.1	98.8	-111.5	100.0
А. Урсгал зарлага	5,713.6	6,537.8	6,353.5	97.2	-184.3	68.4
Бараа, үйлчилгээний зардал	1,993.7	2,459.1	2,359.5	95.9	-99.6	25.4
Хүү	1,046.4	865.6	861.0	99.5	-4.6	9.3
Татаас ба урсгал шилжүүлэг	2,673.5	3,213.1	3,133.0	97.5	-80.1	33.7
Б. Хөрөнгийн зардал	1,206.4	2,740.7	2,548.2	93.0	-192.5	27.4
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	261.9	128.1	393.4	307.1	265.3	4.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.2.5 Нийт зарлагын 68.4 хувь буюу 6,353.5 тэрбум төгрөгийг урсгал зардалд, 27.4 хувь буюу 2,548.2 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд, 4.2 хувь буюу 393.4 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулсан байна.

⁸ 14.2.1-т “жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах”, 31.2-т “... хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлнэ”

3.2.6 Улсын төсвийн урсгал зарлага өмнөх оноос 639.9 тэрбум, хөрөнгийн зардал 1,341.8 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээл 131.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Урсгал зарлага өссөн нь орон нутгийн төсвөөс олгож байсан нийгмийн халамжийн санхүүжилт 326.6 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгосон, Засгийн газрын 2019 оны 24⁹, 25¹⁰ дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг 172.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь нөлөөлжээ.

3.2.7 Төсвийн урсгал зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөснөөс эмнэлгийн бие даасан байдлыг хангаж, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, багшийн үр дүнгийн урамшуулал, нэмэгдлийг ажлын ачаалал, сурагчийн сурлагын амжилттай уялдуулан олгох 2 арга хэмжээ хэрэгжээгүй байна.

3.2.8 Тайлант онд гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр 1,242.3 тэрбум төгрөгийн 112 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,281.3 тэрбум төгрөгийн 91 төсөл, арга хэмжээ хэрэгжиж 103.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс төсөл хэрэгжүүлэгчид санхүүжилтийг шууд олгосон, гадаад валютын ханшийн өсөлт зэргээс шалтгаалан 14 төсөл, арга хэмжээний төсвийг 146.8 тэрбум төгрөгөөр хэтрүүлсэн байна.

3.2.9 Зарим ТЕЗ-дын төсвийн сахилга бат, дотоод хяналт сул, төсвийг үргүй зарцуулсан, цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг эдийн засгийн бусад ангилалд төлөвлөж зарцуулсан, илүү тооцож олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлэн ажилласан зэрэг зөрчлүүд гарсан байна.

3.2.10 Төрийн байгууллагуудын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан 21 байгууллагын 46 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу 0.5 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгож, шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнуудаар төлүүлээгүй байна.

3.2.11 Тайлант онд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 865.6 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 861.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Үүнээс, гадаад өрийн хүүгийн төлбөрт 675.2 тэрбум, дотоод зээл, үнэт цаасны хүүгийн төлбөрт 185.8 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

3.2.12 Гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 507.7 тэрбум, гадаад зээлийн хүүгийн төлбөрт 167.5 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

3.2.13 Тусгай зориулалтын болон улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүүгийн зардалд 185.8 тэрбум төгрөгийг төлжээ. Тухайлбал,

- Улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэхээр гаргасан үнэт цаасны хүү 151.8 тэрбум,
- Өмнөх онуудад Хүний хөгжил сан /хуучин нэрээр/-ийн төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүү 19.9 тэрбум,
- “MCS” ХХК төслийн үнэт цаасны хүүгийн зардал 10.4 тэрбум,
- “Сайн хувьцаа” хөтөлбөрийн үнэт цаасны хүүгийн зардал 3.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

3.3 Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх үр дүн

3.3.1 Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт”-д 31 ТЕЗ-ийн хэрэгжүүлэх 86 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 353 хүрэх үр дүнгийн үзүүлэлт, 19 дэд үзүүлэлтийг баталжээ. Үүнд:

- ХЗДХС 60, Ерөнхий сайд 35, БСШУСС 29, ХНХС 25, ЗТХС 21, Шадар сайд 19, ЭМС 18, УУХҮС 17, Сангийн сайд 14, ХХААХҮС, БОАЖС 12, ГХС, БХБС 10, бусад ТЕЗ 1-7 үзүүлэлтээр хүрэх үр дүнгээ тодорхойлсон байна.

3.3.2 Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, хууль тогтоомж, төрийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусгах чиглэлийг баримтлан 23 хөтөлбөр зориулалт, 113 дэд хөтөлбөр, 324 зориулалт арга хэмжээгээр төлөвлөжээ.

⁹ “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”

¹⁰ “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай”

3.3.3 Зарим ТЕЗ хөтөлбөр, арга хэмжээний хүрэх түвшин, хэрэгжих хугацаа, шалгуур үзүүлэлт зэргийг оновчтой төлөвлөөгүй, хэт ерөнхий байдлаар тусгажээ.

3.3.4 ТЕЗ-д төсвийн хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг төсөвтэй уялдуулан тайлагнаагүй, үр дүнгийн танилцуулгыг бэлтгээгүй, төсвийн зарлагын бодит хэмнэлтийг тооцоогүй байна.

3.3.5 ТЕЗ-дын 2019 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийг Сангийн яаманд ирүүлснийг хянан дүн шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх ажил хангалтгүй байна.

3.4 Улсын төсвийн тэнцэл

3.4.1 2019 онд улсын төсвийн нийт тэнцлийг 2,052.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,317.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 3.7 дахин өссөн байна.

3.4.2 Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд 1,623.6 тэрбум төгрөгийн гадаад зээл авч, Ирээдүйн өв сангаас 50.0 тэрбум, Тогтворжуулалтын сангаас 322.0 тэрбум төгрөгийг тус тус улсын төсөвт шилжүүлж, Ирээдүйн өв сангийн 466.3 тэрбум төгрөгийн авлага барагдуулж, өмч хувьчлалын орлого 0.4 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

3.4.3 Дээрх эх үүсвэрүүдээс Засгийн газрын дотоод үнэт цаасны эргэн төлөлтөд 165.1 тэрбум, гадаад зээлийн үндсэн төлбөрт 438.3 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, 1,317.5 тэрбум төгрөгөөр 2019 оны улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлсэн, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдэл 541.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2019 ОНЫ ТӨСӨВ

4.1 Орон нутгийн төсвийн орлого

4.1.1 Орон нутгийн 2019 оны төсвийн орлого ба тусламжийг 2,917.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1.0 хувиар буюу 30.4 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 178.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 20. Орон нутгийн 2019 оны төсвийн орлого

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2018 оны гүйц	2019 оны			
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	2,769.3	2,917.2	2,947.6	101.0	30.4
Татварын орлого	1,158.8	1,252.4	1,289.2	102.9	36.8
Орлогын албан татвар	814.2	874.1	895.2	102.4	21.1
Хөрөнгийн албан татвар	141.2	148.7	154.3	103.8	5.6
Бусад татвар төлбөр хураамж	203.4	229.6	239.7	104.4	10.1
Татварын бус орлого	1,610.5	1,664.8	1,658.4	99.6	-6.4
Нийтлэг бус татварын орлого	216.9	195.5	209.3	107.1	13.8
Хөрөнгийн орлого	1.1	1.3	0.8	61.5	-0.5
Тусламжийн орлого	1,392.5	1,468.0	1,448.3	98.7	-19.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.1.2 Орон нутгийн нийт орлого ба тусламжийн дүнд татварын орлого 2.9 хувиар давж биелсэн нь Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор газрын төлбөрийн суурь үнэлгээг шинэчлэн баталсантай холбоотой байна.

4.1.3 Татварын бус орлого 1,664.8 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 6.4 тэрбум төгрөгөөр тасарсан нь Өмнөговь аймаг нийтлэг бус татварын орлогыг 5.7 тэрбум, Дорнод аймаг хөрөнгийн орлогыг 0.5 тэрбум төгрөгөөр дутуу биелүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 21. Орон нутгийн 2019 оны нийт орлого ба тусламж

/тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Орлого				Аймаг, нийслэл	Орлого			
	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Архангай	68.7	68.5	99.7	-0.2	Орхон	97.0	109.3	112.7	12.3
Баян-Өлгий	77.2	77.9	100.9	0.7	Өвөрхангай	83.6	85.7	102.5	2.1
Баянхонгор	76.3	77.1	101.0	0.8	Өмнөговь	167.8	169.3	100.9	1.5
Булган	61.0	59.6	97.7	-1.4	Сүхбаатар	54.5	54.0	99.1	-0.5
Говь-Алтай	59.7	59.9	100.3	0.2	Сэлэнгэ	79.7	79.0	99.1	-0.7
Говьсүмбэр	15.5	16.5	106.5	1.0	Төв	79.3	83.0	104.7	3.7
Дархан-Уул	65.7	66.3	100.9	0.6	Увс	80.0	81.1	101.4	1.1
Дорноговь	69.1	68.9	99.7	-0.2	Улаанбаатар	1,381.3	1,380.8	99.9	-0.5
Дорнод	64.2	64.7	100.8	0.5	Ховд	70.1	72.0	102.7	1.9
Дундговь	43.8	44.7	102.1	0.9	Хөвсгөл	94.2	95.9	101.8	1.7
Завхан	64.5	67.6	104.8	3.1	Хэнтий	64.0	65.8	102.8	1.8
Нийт дүн						2,917.2	2,947.6	101.0	30.4

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.1.4 Дээрх хүснэгтээс үзвэл, Архангай, Булган, Дорноговь, Сэлэнгэ, Сүхбаатар аймгуудын орлогын төлөвлөгөө дутуу биелсэн нь СХС-гийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй, тусгай зориулалтын шилжүүлэг, ОНХНС, ЭМДС-гийн санхүүжилтийг дутуу олгосон зэргээс шалтгаалсан байна.

4.1.5 Тайлант онд улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэг 161.0 тэрбум, ОНХС-гийн орлогын шилжүүлэг 138.6 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлгээр 1,140.5 тэрбум, ЭМДС-гаас 5.0 тэрбум, нийт 1,445.1 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд орон нутгийн суурь орлого¹¹ 1,502.5 тэрбум төгрөг байна.

¹¹ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д “орон нутгийн төсвийн суурь орлого” гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг;”

4.1.6 Орон нутгийн төсвийн суурь зардалд санхүүгийн дэмжлэгийн эзлэх хувь өмнөх оноос 2.7 нэгж хувиар буурч 9.6 болсон нь төсвийн төвлөрлийг сааруулж, орон нутгийн бие даах чадавхыг сайжруулсан эерэг үзүүлэлттэй байна.

4.1.7 Орон нутгийн ИТХ өмнөх оны мөнгөн хөрөнгийн 256.1 тэрбум төгрөгийн үлдэгдлээр батлагдсан төсвийг нэмэгдүүлсэн нь нэгдсэн төсвийн алдагдлыг өсгөсөн байна.

4.2 Орон нутгийн төсвийн зарлага

4.2.1 Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 3,229.1 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 2,927.7 тэрбум төгрөг зарцуулж, 90.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 22. Орон нутгийн төсвийн зарлагын эдийн засгийн ангилал

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2018 оны гүйц	2019 оны			
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,762.6	3,229.1	2,927.7	90.7	-301.4
А. Урсгал зардал	2,264.1	2,523.6	2,436.2	96.5	-87.4
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,497.6	1,921.4	1,847.8	96.2	-73.6
Татаас	103.3	159.8	158.1	98.9	-1.7
Урсгал шилжүүлэг	663.2	442.4	430.3	97.3	-12.1
Б. Хөрөнгийн зардал	474.0	664.9	468.5	70.5	-196.4
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	24.5	40.6	23.0	56.7	-17.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.2.2 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 83.2 хувийг урсгал, 16.0 хувийг хөрөнгийн, 0.8 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.

4.2.3 Хөрөнгийн зардал өмнөх оноос 5.5 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 1.5 тэрбум төгрөгөөр буурч, урсгал зардал 172.1 тэрбум төгрөгөөр буюу 7.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 23. Аймаг, нийслэлийн 2019 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

/тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Зарлага				Аймаг, нийслэл	Зарлага			
	Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
Архангай	71.7	67.9	94.7	-3.8	Орхон	111.6	99.6	89.2	-12.0
Баян-Өлгий	79.7	77.9	97.7	-1.8	Өвөрхангай	87.3	84.1	96.3	-3.2
Баянхонгор	79.8	76.5	95.9	-3.3	Өмнөговь	225.3	194.3	86.2	-31.0
Булган	65.2	60.7	93.1	-4.5	Сүхбаатар	56.7	53.2	93.8	-3.5
Говь-Алтай	64.7	62.1	96.0	-2.6	Сэлэнгэ	81.8	79.0	96.6	-2.8
Говь-сүмбэр	17.3	16.5	95.4	-0.8	Төв	85.2	81.2	95.3	-4.0
Дархан-Уул	68.5	65.8	96.1	-2.7	Увс	83.4	80.5	96.5	-2.9
Дорноговь	71.3	68.0	95.4	-3.3	Улаанбаатар	1,553.7	1,353.4	87.1	-200.3
Дорнод	67.9	64.6	95.1	-3.3	Ховд	72.0	69.6	96.7	-2.4
Дундговь	47.8	44.2	92.5	-3.6	Хөвсгөл	100.8	97.3	96.6	-3.5
Завхан	68.6	66.7	97.2	-1.9	Хэнтий	68.8	64.6	93.9	-4.2
Нийт дүн						3,229.1	2,927.7	90.7	-301.4

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.2.4 Орон нутгийн төсвийн нийт зарлага 301.4 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь зарим томоохон хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс шалтгаалан хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаатай холбоотой байна.

4.2.5 Орон нутгийн ТЕЗ, түүний харьяа зарим байгууллага төсвийн сахилга бат, дотоод хяналт сул байгаагаас 1.3 тэрбум төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

4.2.6 Төрийн байгууллагуудын ажил олгогчийн буруугаас ажлаас халагдсан 82 байгууллагын 124 ажилтанд шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олговорт 1.0 тэрбум төгрөгийг¹² олгоходоо буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.

¹² Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1

4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл

4.3.1 Орон нутгийн 2019 оны төсвийн нийт тэнцлийг 311.9 тэрбум төгрөгийн алдагдалтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 19.9 тэрбум төгрөгийн ашигтай гарч, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

4.3.2 Төсвийн нийт тэнцэл ашигтай гарахад нийслэл болон 16 аймаг нийт 49.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь нөлөөлжээ.

БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСӨВ

5.1 Нийгмийн даатгалын сангийн орлого

5.1.1. НДС-гийн орлогыг 2,208.8 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 2,485.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 276.2 (12.5%) тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Хүснэгт № 24. Нийгмийн даатгал сангийн орлого /тэрбум төгрөг/

№	Орлогын төрөл	2018 оны гүйц	2019 он			
			Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	1,139.4	1,258.3	1,469.5	116.8	211.2
2	Тэтгэмжийн даатгал	128.5	132.9	157.5	118.5	24.6
3	ҮОМШӨ-ний даатгал	171.2	169.1	211.0	124.8	41.9
4	Ажилгүйдлийн даатгал	41.1	43.0	41.5	96.5	-1.5
5	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	609.8	605.5	605.5	100.0	-
	Нийт дүн	2,090.0	2,208.8	2,485.0	112.5	276.2

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны мэдээлэл

оноос 44.9 тэрбум төгрөгөөр өсжээ.

5.1.4. Хадгаламжийн хүү 68.0 тэрбум, харилцах дансны үлдэгдэлд бодогдсон хүү 19.0 тэрбум, нийт 87.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлжээ.

5.2 Нийгмийн даатгалын сангийн зарлага

5.2.1. НДС-гийн зарлагыг 2,068.5 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 2,062.3 тэрбум төгрөг зарцуулж, 99.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 25. Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөг/

№	Ангилал	2018 оны гүйц	2019 он			
			Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	1,619.3	1,859.9	1,839.2	98.9	-20.7
2	Тэтгэмжийн даатгал	112.1	114.2	124.2	108.8	10.0
3	ҮОМШӨ-ний даатгал	29.9	32.9	30.8	93.6	-2.1
4	Ажилгүйдлийн даатгал	34.4	36.8	43.6	118.5	6.8
5	Үйл ажиллагааны урсгал зардал	18.9	24.7	24.5	99.2	-0.2
	Дүн	1,814.6	2,068.5	2,062.3	99.7	-6.2

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2019 оны мэдээлэл

5.1.2. НДС-гийн нийт орлого нэмэгдэхэд өмнөх оноос ажил олгогчийн тоо 2.4 мянга, даатгуулагчийн тоо 52.6 мянган хүнээр, даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувь хэмжээ 1 хувиар нэмэгдсэн нь тус тус нөлөөлсөн байна.

5.1.3. Тайлант онд харилцах дансны үлдэгдэл 314.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн ба 224.4 тэрбум төгрөгийн хадгаламж нэмж байршуулснаар жилийн эцэст арилжааны 10 банканд 484.2 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжтай байгаа нь өмнөх

5.2.2. НДС-гийн төсвийг 6.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулахад 13.5 мянган малчин иргэнийг өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 9.4 мянган иргэн тэтгэвэр тогтоолгосон нь нөлөөлсөн байна.

5.2.3. Тайлант онд үйл ажиллагааны зардалд 24.7 тэрбум төгрөг батлагдсанаас 24.5 тэрбум төгрөг буюу 99.2 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл.

5.3.1. НДС-гийн төсвийн тэнцлийг 140.3 тэрбум төгрөгийн ашигтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 422.7 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

БҮЛЭГ 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2019 ОНЫ ТӨСӨВ

6.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

6.1.1 ЭМДС-гийн нийт орлогыг 407.7 тэрбум төгрөгөөр баталснаас, 469.6 тэрбум төгрөг төвлөрч, орлогын гүйцэтгэл 61.9 (15.2%) тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

Хүснэгт 26. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого /тэрбум төгрөг/

№	Орлогын төрөл	2018 оны гүйц	2019 он			
			Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	ААНБ-ын ажил олгогчийн төлөх шимтгэл	112.1	100.6	123.4	122.7	22.8
2	Даатгуулагчийн төлөх шимтгэл	125.9	122.5	150.4	122.8	27.9
3	Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	41.5	44.5	54.5	122.5	10.0
4	Төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл	67.5	83.9	83.8	99.9	-0.1
5	Бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	16.5	16.8	14.8	88.1	-2.0
6	Бусад орлого	47.6	39.4	42.7	108.4	3.3
ДҮН		411.1	407.7	469.6	115.2	61.9

6.1.2 ЭМДС-гийн нийт орлогын 69.9 хувийг аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэл, 17.8 хувийг төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэл, 3.2 хувийг бусад даатгуулагчийн төлөх шимтгэл, 9.1 хувийг бусад орлого тус тус бүрдүүлж байна.

6.1.3 ЭМД-д 2920.8 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 90.2 хувьтай, буюу өмнөх оноос 1.3 хувиар нэмэгдсэн байна.

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн мэдээлэл

6.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлага

6.2.1 ЭМДС-гийн нийт зарлагыг 407.7 тэрбум төгрөгөөр баталснаас 351.0 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 86.1 хувьтай байна.

6.2.2 Тайлант онд давхардсан тоогоор 8.6 сая даатгуулагчдын тусламж, үйлчилгээний зардалд 346.1 тэрбум төгрөгийг 1970 гаруй ЭМБ-д олгосон байна.

Хүснэгт 27. Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлага

/тэрбум төгрөг/

№	Зардлын ангилал	2018 оны гүйц	2019 он			
			Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү
1	Төрийн өмчийн ЭМБ-дад олгох	213.2	244.7	236.8	96.8	-7.9
2	Хувийн эмнэлэг, эмийн санд олгох	94.9	148.7	105.3	70.8	-43.4
3	Сум тосгоны ЭМТ-д олгох санхүүжилтийн зардал		8.7	4.0	46.1	-4.7
4	Үйл ажиллагааны урсгал зардал	3.6	5.4	4.6	85.1	-0.8
5	Шимтгэлийн буцаан олголт		0.24	0.26	108.0	-0.1
Дүн		311.7	407.7	351.0	86.1	-56.7

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын сангийн мэдээлэл

6.2.3 Хувийн эмнэлэг, эмийн санд олгох тусламж үйлчилгээний зардал 43.4 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

6.2.4 Спорт клубыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулаагүйгээс идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх үйлчилгээнд төлөвлөгдсөн 2.0 тэрбум төгрөг зарцуулагдаагүй байна.

6.2.5 “Цахим жор” программ хангамжийг нэвтрүүлснээр эмийн сангуудаар олгох хөнгөлөлттэй эмийн зардалд тавих хяналт сайжирч, 11.0 тэрбум төгрөг хэмнэгдсэн байна.

6.2.6 Хувийн хэвшлийн ЭМБ-д олгох санхүүжилтээс 13.6 тэрбум төгрөгийг дутуу зарцуулсан байна. Үүнд:

- Иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг оношилгоо шинжилгээнд хамрагдалт хангалтгүйгээс 6.2 тэрбум;
- Өрхийн 85 эмнэлэг 4 төрлийн тусламж үйлчилгээний сонгон шалгаруулалтад хамрагдаагүйгээс 3.2 тэрбум;
- Гэрээний шаардлага хангаагүй 15 лабораторийн санхүүжилтийг түр зогсоосноос В, С вирусийн идэвхжил тодорхойлох шинжилгээний 4.2 тэрбум төгрөг.

6.2.7 Тайлант онд үйл ажиллагааны зардалд 5.4 тэрбум төгрөг батлагдсанаас 4.6 тэрбум төгрөг буюу 85.1 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

6.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

6.3.1 ЭМДС-гийн 2019 оны төсвийн зардлыг орлогод нийцүүлэн 407.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр төсвийн тэнцэл 118.6 тэрбум төгрөгийн ашигтай гарч, мөнгөн хөрөнгө өссөн байна.

БҮЛЭГ 7. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

7.1 Тайлант онд 625.4 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос 312.8 (50.0%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт эх үүсвэрийн 39.5 хувийг төсвөөс, 60.5 хувийг төсвийн бус эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

7.2 Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дараах нэр төрлийн орлогоос бүрджээ. Үүнд,

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 162.7 тэрбум;
- Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 84.2 тэрбум;
- Хандив тусламж 65.8 тэрбум;
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 312.7 тэрбум;
- Урьд оны үлдэгдлээс санхүүжих 15.8 тэрбум төгрөг байна.

7.3 Нэмэлт төсвийн санхүүжилтээс 603.3 тэрбум төгрөг зарцуулснаас 86.2 хувийг урсгал зарлагад, 12.5 хувийг хөрөнгийн зардалд, 1.3 хувийг бусад зардалд зарцуулсан байна.

7.4 Нэмэлт төсвийн зарлагын 82.7 хувийг улсын төсвийн, 17.3 хувийг орон нутгийн төсвийн зарлага эзэлж байна.

7.5 Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагуудын өөрийн үйл ажиллагааны орлогоор нийт 312.7 тэрбум төгрөг төвлөрснөөс Сангийн сайдын 2019 оны 185, 251 тоот тушаалуудаар 19.0 тэрбум төгрөгийг зарцуулах эрх олгосон байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 4, Сангийн сайдад 4, нийт 8 зөвлөмж өгсөн.

Сангийн яамнаас ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад хянаж үзэхэд бүрэн хэрэгжүүлээгүй 65.0 хувьтай байгаа нь төсвийн бодлого, түүний хэрэгжилт сайжрах боломжуудыг алдсан байна.



ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Тайлант оны төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 756.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан нь ДНБ-ний 2.0 хувьтай тэнцүү, батлагдсан үзүүлэлтээс 3.4 нэгж хувиар буурч, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.
2. Тайлант онд “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх хүрээнд 7 бодлогын зорилт дэвшүүлснээс 5 зорилтыг хангаж, 2 зорилт дунд хугацаанд хүлээгдэх үр дүнтэй байна.
3. Сүүлийн 3 жилийн байдлаар орлогын өсөлтийн хурд саарсан, зарлагын өсөлтийн хурд идэвхжих хандлагатай байна.
4. Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцоолж, тусгаагүйгээс батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулсан, Төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг төсвийн төлөвлөлтөд 3, төсвийн гүйцэтгэлд 1 үзүүлэлтээр тус тус хангаагүй байна.
5. Татварын бүртгэл, мэдээллийн системд хамрагдалт сайжирсан, уул уурхайн голлох нэр төрлийн зарим эрдэс бүтээгдэхүүний биет хэмжээ, үнэ өмнөх оноос өссөн, тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний үр дүнд экспорт, гадаад худалдааны эргэлт нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас төсвийн татварын орлого төлөвлөснөөс давж биелсэн байна.
6. Өрийн өнөөгийн үнэ цэнэ болон ДНБ-ний харьцаа 55.6 болж зорилтот түвшнээс 0.3 хувиар хэтэрсэн ч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн шаардлагыг хангаж байна.
7. Орон нутгийн ИТХ өмнөх оны мөнгөн хөрөнгийн 256.1 тэрбум төгрөгийн үлдэгдлээр батлагдсан төсвийг нэмэгдүүлсэн нь нэгдсэн төсвийн алдагдлыг өсгөсөн байна.
8. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх төлөвлөлт, гүйцэтгэл нь шийдвэр гаргалтад ашиглах ач холбогдол багатай, үр дүнгийн шалгуур үзүүлэлт тохиромжгүй, зарим хүрэх үр дүнгийн хэрэгжих боломжтой хугацааг үндэслэлтэй тооцоолоогүй, өртөг тооцоололт хангалтгүй байна.
9. Засгийн газарт 2021-2024 онд төлөгдөх 2.9 тэрбум ам.долларын гадаад бондын өрийг барагдуулах үүрэг хүлээгдэж байна.

Монгол Улсын Их Хуралд толилуулах нь:

Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн нийт орлого ба тусламжийн 12,040.3 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн 11,661.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн тухай хуулийг хэлэлцэж, батлахдаа төсвийн тогтвортой байдлыг хангах хуулийн шаардлагыг баримталж, өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн, өөрчлөлт хийхгүй байх.

Засгийн газар ба орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын төсвийн эрх мэдлийн хуваарилалтыг нэгдмэл зохицуулалтад оруулж эрх зүйн орчныг сайжруулах.

ТЕЗ-д өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилт, дүнг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороогоор хэлэлцүүлэн төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гаргуулах саналыг уламжилж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Үр дүнд чиглэсэн хөтөлбөрт төсөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд улсын салбарын түвшинд хөтөлбөрийн хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн иж бүрэн систем бий болгож ажиллах.
2. Төсвийн бодлогын хүрээнд тайлант онд дэвшүүлсэн зорилтоо бүрэн хэрэгжүүлэхэд анхаарал хандуулж, үр дүнг тооцож ажиллах.
3. Төсөв боловсруулах, өргөн мэдүүлэхдээ эдийн засгийн өсөлттэй уялдуулан хүлээгдэж буй өрийг барагдуулах ажлыг төсөвт хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулах.

Сангийн сайдад:

1. Сүүлийн 3 жилийн байдлаар нэгдсэн төсвийн орлогын өсөлтийн хурд саарсан, зарлагын өсөлтийн хурд идэвхжих хандлагатай байгааг анхаарч, төсвийн тогтвортой байдлыг хангаж ажиллах.
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг тооцох аргачлалд орон нутгийн төсвийн зарлагын дээд хязгаарыг хэрхэн тооцож хянах талаар тодорхой тусгаж, дээд шатны төсөвт тодотгол хийгээгүй үед орон нутгийн төсөвт өөрчлөлт оруулахыг зогсоох.